

“Нэйшнл лайф даатгал” ХХК-иас төвлөрүүлэх  
зохицуулалтын үйлчилгээний хөлсний  
хэмжээг тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.5, Даатгалын тухай хуулийн 14.2.17, Санхүүгийн зохицуулах хорооны дүрмийн 5.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн үйл ажиллагаа жигдэрч, тодорхой даатгуулагчидтай болтол нь дэмжлэг үзүүлэх үүднээс 2008 онд Хороонд төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг 5 сая төгрөгөөр тогтоосугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 2008 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Хороонд төвлөрүүлэхийг “Нэйшнл лайф даатгал” ХХК /Б.Батбаяр/-д даалгасугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ